

БАТЛАВ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА И.БАТТӨГС

2023 оны 04 дүгээр сарын 17 өдөр

"ОЛОН УЛСЫН ЭКО ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН (АЙ ЖИ ЭМ)"-ИЙН ЦАХИЛГААН
ХАНГАМЖИЙН АЖИЛ (УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 28 ДУГААР ХОРОО)
ЗУРГИЙН ДААЛГАВАР

2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">- Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 9 дүгээр хуралдааны 56 дугаар тогтоол;- Эрчим хүчний яамны 07/2023/96 дугаартай техникийн нөхцөл;
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	<ul style="list-style-type: none">- Баянзүрх дүүргийн 23, 28 дугаар хороо, Олон Улсын эко цэцэрлэгт хүрээлэн;
3	Зориулалт, хүчин чадал	<p><u>Орчны нөхцөл байдалд уялдуулан</u></p> <ul style="list-style-type: none">- 35/10 кВ-ын "ОД" дэд станцын 10кВ-ын хуваарилах байгууламжийн 10кВ-ын I ба II секцийг 2 гаргалгаагаар өргөтгөн, хос кабель шугам /2 ширхэг/ татаж, шинээр баригдах 10/0.4кВ-ын 2х800кВА хүчин чадалтай дэд станцын I ба II секцийг холбох;- Олон улсын "IEC-61850" цуврал стандартын шаардлага хангасан микропроцессорын реле хамгаалалт (газардуулга, нумын, АПВ, АЧР гэх мэт) цахилгаан байгууламжийн дүрэм (БД43-101-03) болон ТАД-д заасан бүх төрлийн хамгаалалтыг суулган программчлах боломжтой байх;- Микропроцессорын хамгаалалтыг SCADA системд холбох;- Шинээр баригдах дэд станцын 10кВ-ын I ба II секцээс хос кабель татаж "Хужирбулан" фидерийн тулгуур № 175-д холбох;- Цахилгаан дамжуулах агаарын шугам нь MNS 6518:2015 стандартын шаардлага хангасан байх ба утасны дамжуулагчийн хөндлөн огтлолыг тооцоогоор сонгох;- Шинээр татах 10 кВ-ын кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор тодорхойлон, ашиглагч байгууллагатай зөвшилцөх;- Холбогдох тооцооны дагуу ачаалал хэрэглээнд тохирсон коэффициент бүхий гүйдлийн трансформатор суурилуулах;- Олон улсын IEC 61861 стандартын шаардлагыг хангасан, реле хамгаалалт, хэмжүүр, хянах хэмжих хэрэгсэлд тавигдах

		шаардлагуудыг бүрэн хангасан, 0.2 нарийвчлалтай гүйдлийн трансформатор суурилуулах;
4	Зураг төслийн бүрдэл	<p><u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> - Ажлын зураг төсөл боловсруулахдаа Монголын Улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллага болон Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Олон улсын цэцэрлэгт хүрээлэн “Ай жи эм” тус тус газруудтай зөвшилцсөн байх; - Зураг төсөл боловсруулах шатанд холболт хийх цэг, ячейкны дугаар, шуурхай ажиллагааны нэр, зарчмын схем, хоёрдогч хэлхээний зургийг ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-тай зөвшилцөх;
5	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгох;
6	Зураг төслийн байгууллага	- Захирамжийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага байх;
7	Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага	- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар;
8	Инженерийн хангамж	- Техникийн нөхцөлд дурдсан инженерийн хангамж;
9	Онцгой нөхцөл	<p><u>Анхаарах зүйл:</u></p> <ul style="list-style-type: none"> - Дэд станц, цахилгаан дамжуулах шугамын байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд орон зайн мэдээллийг оруулах;
10	Төлөвлөлтөд тавигдах шаардлага	<p><u>Дараах байгууллагуудтай заавал зөвшилцсөн байна:</u></p> <ul style="list-style-type: none"> - УБЦТС ТӨХК; - Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар; - Олон улсын цэцэрлэгт хүрээлэн ААТҮГ “Ай жи эм”; - Холбогдох бусад байгууллагатай;
11	Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөв боловсруулах	- Шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах, угсралт, туршилт, тохируулгын ажлыг “Цахилгаан байгууламжийн угсралтын дүрэм” (2003 он), Эрчим хүчний тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх “Тусгай зөвшөөрөл” бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх;

		<ul style="list-style-type: none"> - “Эрчим хүчний тухай” хуулийн 29.1.9-д “Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж болох эрхтэй” гэж заасны дагуу өөрийн тоноглолоос хангагч байгууллагын зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй байх; <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын цахилгаан байгууламжийн дүрэм, Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу гүйцэтгэх; - Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12; - Бусад холбогдох норм, дүрэм; <p><u>Төсөл, хөтөлбөрүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл; - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
12	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> - Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох;

ХЯНАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ДАВААСАМБУУ

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.БИЛЭГСАЙХАН


БОЛОВСРУУЛСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.БАТБАЯР

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.АЛТАНЗАЯА

БАТЛАВ. ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН
ХЭСГИЙН ДАРГА Б.НАСАНТОГТОХ - Г



Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23, 28-р хорооны нутаг дэвсгэрт байгуулагдах
цэцэрлэгт хүрээлэн, тохижилтийн ажлын цахилгаан хангамжийн

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Олгосон огноо.

2023.03.29

№

07/2023/96

Улаанбаатар хот

**1. Техникийн нөхцөл хүссэн иргэн,
хуулийн этгээдийн нэр, хаяг**

**“НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР”**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө-57,

**“ОЛОН УЛСЫН ЭКО ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН”
ААТҮГ**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө-57, Баянзүрх дүүргийн
Засаг даргын тамгын газрын байр,

2. Техникийн нөхцөл хүссэн байршил

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 23, 28-р хороо,

3. Ажил үйлчилгээний зориулалт

Цэцэрлэгт хүрээлэн, тохижилтийн ажлын
цахилгаан хангамж

**4. Техникийн нөхцөл олгох, сунгах
үндэслэл**

- Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн
0000037170 дугаартай гэрчилгээ,

- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын
2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/240
дугаар захирамж,

- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын
тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 06-ны
өдрийн 108 дугаар тогтоол

- Нийслэлийн засаг даргын 2021 оны 10 дугаар
сарын 14-ний өдрийн А/784 дугаар захирамж,

- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын
2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/240
болон 10 дугаар сарын 20-ны өдрийн А/539
дугаартай захирамжууд,

- Нийслэлийн ерөнхий архитектор бөгөөд хот
байгуулалт хөгжлийн газрын даргын баталсан
2021 оны 12 дугаар сарын 02-ний МЗХ2021/22-016
дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн
даалгавар,

- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02/418 тоот албан бичиг,

- "Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын www.new.tog.mn цахим системийн 23-99-000384 дугаартай хүсэлт,

- Эрчим хүчний сайдын 2022 оны А/96 дугаар тушаалаар байгуулагдсан "Цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх ажлын хэсэг"-ийн 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн хурлын шийдвэрийн товч тэмдэглэл

5. Олгосон чадал

1500 кВА

6. Тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага

6.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орж, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.

6.2 RS-485-ийн гаралтын интерфэйстэй олон улсын IEC61107, IEC62056 холболтын стандартуудын шаардлага хангасан байх,

6.3 Санах ой бүхий 0.2 нарийвчлалтай бүрэн электрон тоолуур суурилуулах.

6.4 Шинээр суурилуулж буй тоолуурууд нь тоолуурын нэгдсэн системд холбох. Мэдээлэл дамжуулах боломжийг бүрдүүлсэн байх.

6.5 Тоолуур, хянах, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагыг хангагч байгууллага "УБЦТС" ТӨХК-аас авах. Ажлын зураг төсөл боловсруулах шатанд суурилуулах тоолуурын төрөл, марк, схемийг тухайн байгууллагаар хянуулсан байх,

7. Гүйдлийн трансформаторт тавигдах шаардлага

7.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.

7.2 Холбогдох тооцооны дагуу ачаалал хэрэглээнд тохирсон коэффициент бүхий гүйдлийн трансформатор суурилуулах.

7.3 Олон улсын IEC 61861 стандартын шаардлагыг хангасан, реле хамгаалалт, хэмжүүр, хянах хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагуудыг бүрэн хангасан, 0.2 нарийвчлалтай гүйдлийн трансформатор суурилуулах,


8. Холбогдох цэг

8.1 35/10 кВ-ын "Од" дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламжийн 10 кВ-ын I ба II секцийг 2 гаргалгаагаар өргөтгөн, хос кабель шугам /2 ширхэг/ татаж, шинээр баригдах 10/0.4 кВ-ын дэд станцуудын I ба II секцийг тэжээх,

9. Дамжуулах, түгээх сүлжээний шугам, дэд станцыг өргөтгөх шаардлага

9.1 35/10 кВ-ын "Од" хуваарилах байгууламжийн 10 кВ-ын гаргалгааны ячейкууд нь дараах шаардлагыг хангасан байх. Үүнд:

9.1.1 Олон улсын "IEC-61850" цуврал стандартын шаардлага хангасан микропроцессорын реле хамгаалалт (газардлагын, нумын, АПВ, АЧР гэх мэт)



цахилгаан байгууламжийн дүрэм (БД43-101-03) болон ТАД-д заасан бүх төрлийн хамгаалалтыг суулган программчлах боломжтой байх. Микропроцессорын хамгаалалтыг SCADA системд холбох,

9.1.2 Халаагуурын систем, температурын датчик, кабелийн холболтын камерт нумын хамгаалалт, фазын дараалалын индикатор зэргээр тоноглогдсон байх, тэг дарааллын гүйдлийн трансформатор суурилуулж, газардлагын хамгаалалтыг оруулах

9.1.3 Шинэ ячейканд тавигдах гүйдлийн трансформатор нь өсөн нэмэгдэх ачаалалд тохирсон коэффициент бүхий 0.2 нарийвчлалтай, реле хамгаалалт, хэмжүүр, тоолуурыг тооцсон ороомогтой байх

9.2 Шинээр татах 10 кВ-ын хос кабель шугам нь MNS 6819:2015 стандартын шаардлагыг хангасан байх.

9.3 Шинээр татах 10 кВ-ын хос кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор тодорхойлон, ашиглагч УБЦТС ТӨХК-тай зөвшилцөн сонгох.

9.4 Шинээр баригдах барилга байгууламжуудын цахилгаан хангамжид хэрэглээ, ачаалалд тохирсон хөндлөн огтлол бүхий хос кабель шугам татаж, 10/0.4 кВ-ын дэд станц /ХТП/-үүд барьж, цахилгаан эрчим хүчээр хангах. Зураг төсөл боловсруулах шатанд холболтын схем, горим ажиллагааг ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-тай зөвшилцөх, батлуулах,

9.5 10 кВ-ын кабель шугамын хөндлөн огтлол, 10/0.4 кВ-ын дэд станц /ХТП/-үүдийн трансформаторын хүчин чадлыг хэрэглээ ачаалалтай уялдуулан тооцоогоор сонгож, Зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-тай зөвшилцөх, батлуулах,

9.6 Дэд станцын 10/0.4 кВ-ын трансформаторууд нь хүчдэл тохируулгын 5 шатлал бүхий олон улсын IEC 60076-10 стандартын шаардлагыг хангасан байх,

9.7 Шинээр баригдах дэд станцын 10 кВ-ын I ба II секцнээс хос кабель татаж, "Хужирбулан" фидерийн тулгуур №175-д холбох. Зураг төсөл боловсруулах явцад ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-тай зөвшилцөх,

9.8 Хуваарилах байгууламж, дэд станцын оруулга, гаргалгааны шугам, тоноглолууд, дизель станцад олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох богино залгааны тооцоонуудыг хийж, ашиглагч УБЦТС ТӨХК-тай зөвшилцөн сонгох.

9.9 Шинээр суурилуулж буй тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, "Эрчим хүчний нэгдсэн сүлжээний дүрэм"-д заасны дагуу $\pm 10\%$ -ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах,

9.10 Хуваарилах байгууламж, дэд станцуудад галын хор, шит, самбар, пунктыг галын аюулгүйн дүрэмд заагдсаны дагуу байрлуулж, галын аюулгүй байдлыг хангах,

9.12 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд, кабель шугам, трансформаторууд, дизель

станц нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх.

9.13 Кабелиуд нь 10 кВ-ын хүчдлийн түвшинд ашиглах, орчны температур -15 хэм байхад угсралт хийх боломжтой байх,

9.14 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа кабель шугамын холболтын муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах.

10. Реле хамгаалалт, автоматикийн байгууламжид тавих шаардлага

10.1 Энэхүү техникийн нөхцлийн дагуу суурилуулах реле хамгаалалт, автоматикийн тоног төхөөрөмжүүд, удирдлага, хяналт, мэдээллийн системүүд нь "Бодлогын бичиг баримт батлах тухай" Эрчим хүчний сайдын 2019 оны 335 дугаар тушаалаар батлагдсан "Реле хамгаалалт, системийн автоматикийн талаар баримтлах бодлогын баримт бичиг", "Эрчим хүчний салбарт баримтлах мэдээллийн технологийн бодлогын баримт бичиг"- шаардлагуудыг бүрэн хангах, хангагч байгууллага "УБЦТС" ТӨХК-уудтай зураг төсөл боловсруулах шатанд зөвшилцсөн байх.

10.2 Хуваарилах байгууламж, шугам, дэд станцын оруулга, гаргалгааны тоноглолуудад олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох богино залгааны тооцоонуудыг хийж, ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-тай зөвшилцөн сонгох.

10.3 Реле хамгаалалт автоматикийн тавилын тооцоог хангагч байгууллага УБЦТС ТӨХК-аар хийлгэх.

11. Реактив чадлын зохицуулалт

-

12. Цахилгаан эрчим хүчний чанарыг хянах хэрэгсэл, чанарын үзүүлэлтийг тогтворжуулах төхөөрөмжийн хэрэгцээ

-

13. Нэг маягийн зураг төсөл хэрэглэх зөвлөмж


13.1 Зургийн даалгаврыг Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газраас авах.

13.2 Ажлын зураг төсөл боловсруулахдаа Монголын Улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 5 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллага болон УБЦТС ТӨХК-уудтай зөвшилцсөн байх.

13.3 Зураг төсөл боловсруулах шатанд холболт хийх цэг, ячейкны дугаар, шуурхай ажиллагааны нэр, зарчимын схем, хоёрдогч хэлхээний зургийг ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-тай зөвшилцөх.

14. Гэнэтийн гэмтэл саатал, аваарийн үед ашиглах бэлтгэл тэжээл, бие даасан цахилгааны түсгүүр суурилуулах шаардлага

-



15. Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүйн ажиллагааны байдал

15.1 “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.8 “Өөрийн эзэмшлийн шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах” гэж заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнгын үзлэг шалгалт хийх, хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх.

15.2 “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.13 “Нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх гэж заасны дагуу хангагч байгууллага “УБЦТС” ТӨХК-д хүлээлгэн өгөх.

16. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа

16.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.9-д заасны дагуу 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийг хүртэл /1 жилийн хугацаанд/ хүчинтэй.

16.2 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.13-д заасны дагуу **техникийн нөхцөлийн дагуу зураг төслийн байгууллагаар хийлгэж, холбогдох байгууллагаар хянуулж, эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж баталгаажуулсан байна.**

16.3 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгуулахдаа хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.16-д заасны дагуу баталгаажуулсан зураг төслийг ирүүлнэ. **Хэрэв баталгаажуулсан зураг төсөл ирүүлээгүй тохиолдолд техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгахгүй.**

17. Дагаж мөрдөх хууль, дүрэм, журам

17.1 Дэд станц, цахилгаан дамжуулах шугамын байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд орон зайн мэдээллийг оруулах,

17.2 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад трассын дагуу дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээх зардлыг төсөвт тусгах,

17.3 Шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах, угсралт, туршилт, тохируулгын ажлыг “Цахилгаан байгууламжийн угсралтын дүрэм” (2003 он), Эрчим хүчний тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх “Тусгай зөвшөөрөл” бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх

17.4 “Эрчим хүчний тухай” хуулийн 29.1.9 “Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж болох эрхтэй” гэж заасны дагуу

өөрийн тоноглолоос хангагч байгууллагын зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй.

18. Техникийн нөхцөлийн хүчингүйд тооцох заалт

18.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.

2.17 дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

2.17.1. хүчинтэй хугацаа дууссан;

2.17.2. техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

2.17.3. холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн;

2.17.4. дамжуулагчаас санал аваагүй, өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо дамжуулах сүлжээнд холбогдох техникийн нөхцөлд заагдсан хүчин чадлаас хэтрүүлсэн.

18.2 Олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд

АЖЛЫН ХЭСГИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЖЛЫН ХЭСГИЙН ОРЛОГЧ ДАРГА:

ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ЦАХИЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА  Д.БАТЗОРИГ

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:

"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  Б.ЭРХЭМЗАЯА

"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  Т.МӨНХБОЛД

АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ЦАХИЛГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ ШИНЖЭЭЧ  М.ГАНСҮХ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ:

Хүсэлт гаргасан иргэн буюу хуулийн этгээдийг төлөөлж:

Хүлээн авч, техникийн нөхцөлийн заалтууд, тухайн техникийн нөхцөл хүчингүйд тооцох заалттай танилцсан эсэх

Тийм

Үгүй

Нэр: 

Регистрийн дугаар: 7E660821968

Холбоо барих: 99028317

Огноо: 2023. 04. 12

Гарын үсэг: 